

МОНГОЛ, ЭНЭТХЭГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Доктор О.Нямдаваа

Манай өвгөд дээдэс аль эрт дээр үеэс Энэтхэгт өөрөөр хэлбэл Бурхан багшийн хувилгаан дүрээ олсон оронд суралцах ажиллах хүсэл эрмэлзэл ихтэй байж, түүнийгээ хэрэгжүүлж ирсэн сайхан түүхтэй. Энэхүү байдлыг орчин үетэй зохицуулан, улмаар 1960-д оноос эхлэн Соёлын салбарын хамтын ажиллагааны Хэлэлцээр Монгол, Энэтхэг орны хооронд байгуулан ажиллаж түүнийгээ улам баяжуулан өргөтгөж ирлээ.

Энэтхэгийн сургалтын чанар, түвшин бол орчин үеийн өрнөдийн орнуудынхтай мөр зэрэгцэн явдаг. Түүний зэрэгцээ их дээд сургуулийн хичээл англи хэлээр явагддаг учир мэргэжил эзэмшихээс гадна, англи хэлтэй болдгоороо Ази болон Европын зарим орноос давуутай. Европ, Америкт шинэ ямар онол, бүтээл гарна тэр нь шууд маргааш өдөртөө багтан Энэтхэгт орж ирдэг учраас энэтхэгчүүд өөрсдийгөө орчин үетэй мөр зэрэгцэн алхаж байгаа гэж үздэг. Нөгөөтэйгүүр гадаадын оронд гарч байгаа онол, бүтээлүүд Энэтхэгийн хөрсөн дээр яаж буух ёстой, юу нь тохирч байна, юу нь тохирохгүй байгаа, юуг шинээр тусгах хэрэгтэйд Энэтхэгийн эрдэмтэд бүтээлчээр хандаж шинэчлэн гаргадгаараа онцлогтой байдаг. Ийм оронд монгол хүн суралцана гэдэг бол их аз завшаантай хэрэг бөгөөд өөрийнхөө чадал, хүсэл эрмэлзлээрээ их зүйлийг сурах, бүтээн бодох, шинээр бий болгох бүрэн боломжоор хангагдсан байдаг.

Энэтхэг орон харилцаа холбо, мэдээллийн технологи, программ хангамжийг бүтээх талаараа дэлхийг хошуучилж, тэргүүлэх байр суурь эзэлж байгаа бөгөөд энэхүү ололт амжилтаа Монгол анд нөхөдтэйгээ хуваалцахдаа баяртай байдаг. Түүний нэгэн илрэл болох дараах буцалтгүй тусламж дэмжлэгийг Энэтхэгийн засгийн газраас үзүүлж ирлээ.

- Энэтхэгийн Ерөнхий сайд асан А.Б.Важпайн нэрэмжит Харилцаа холбоо мэдээллийн технологийн дээд сургуулийг Энэтхэгийн засгийн газар Улаанбаатарт байгуулж, нэг сая ам. долларын буцалтгүй тусламж үзүүлж, улмаар Монгол Энэтхэгийн хооронд шууд видео бага хурал хийх, Энэтхэгийн багш нарын лекцийг Монгол оюутан сонсох боломжоор хангалаа.
- Үйлдвэрлэл урлалын сургуулийг байгуулж түүнийг Р.Гандийн нэрэмжит болгон, түүнд зориулсан танхим бий болгосон нь Энэтхэгийн анхны Ерөнхий сайд, Монголын тухай сонин сайхан мэдлэгтэй байж, түүнийхээ талаар номондоо бичиж, Монголыг НҮБ-д элсэхийг тууштай дэмжиж байсан Неругийн гэр бүлийнхний үйл амьдралыг олж мэдэх боломжийг бий болгов. Тэнд Энэтхэгийн Засгийн газрын техник эдийн засгийн тусламжаар 8 анги нээгдээд байна.
- Монгол Энэтхэгийн хамтарсан дунд сургууль байгуулагдаад цөөн хэдэн жил болж байна. Энэ сургууль англи хэл, тоо математик, компьютерийн хичээлээр тэргүүлсэн сургууль болохоор ажиллаж байна. Тэнд энэтхэгийн багш нар сүүлийн 3 жил тасралтгүй ажиллаж манай орны хүүхдийг сургаж байна.

Эдгээр зүйлүүд нэгэн өдөр бий болоогүй. Монгол, Энэтхэгийн хооронд дипломат харилцаа тогтоосон 50 гаруй жилийн түүхэн явцад ажилласан манай

хоёр орны дипломат ажилтнуудын үйл ажиллагааны үр дүн билээ. Миний бие энэ харилцааны 30 гаруйд өөрийн биеийг зориулсан билээ.

- Энэтхэгийн Засгийн газрын техник эдийн засгийн хамтын ажиллагааны АЙТЕК хөтөлбөрийн дагуу Энэтхэгийн зардлаар жилд 50 гаруй монгол хүмүүс мэргэжил дээшлүүлж байна. Энэ хөтөлбөрөөр 1990-ээд оноос эхлэн манайхан суралцаж эхэлсэн боловч, суралцагсдын тоо түргэн өсч, үр дүнгээ өгч байгаа. Тэдний дотор англи хэлээр суралцан төгссөн хүмүүс Энэтхэгчүүд англи хэл заадаг арга барилыг Монголын нөхцөлд тохируулан хэрэглэх сайхан туршлагатай болоод нутагтаа ирж байна.

1990-ээд оноос эхлэн Энэтхэгийн их дээд сургуулиудад Монгол оюутан суралцах шинэ үе эхэлсэн. Түүнээс өмнө монголчууд зөвхөн Хинди хэлний сургуульд суралцаж байв. Хинди хэл үзсэн ахмадууд Энэтхэгийн сонгодог уран зохиол болон орчин үеийн өгүүдэл яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиолыг орчуулан олон түмний хүртээл болгож ирлээ.

Энэтхэгийн Засгийн газрын цалингаар, Энэтхэгийн дуртай сургуульдаа суралцах боломжоор монгол оюутнууд бүрэн хангагдлаа. Энэ тоо жил бүр 30 гаруйд хүрч нэмэгдэж байна. Түүний зэрэгцээ өөрсдийн зардлаар Энэтхэгийн их дээд болон дунд сургуульд суралцах хандлага сүүлийн үед нэмэгдсээр байна. Ялангуяа дотуур байртай хатуу дэг журамтай дунд сургуульд хүмүүс хүүхдээ явуулах сонирхолтой болж байна.

Энэтхэгийн боловсролын систем түүний онцлог

Энэтхэгийн боловсрол, сургалтын систем өнөөгийн дэлхий дахины хэмжээнд байж орчин үеийн шинжлэх ухаан техник, компьютерийн эрин үетэй хөл нийлүүлэн алхаж өөрчлөлт шинэчлэлтээ байнга хийж байна.

Энэтхэгчүүд олон үндэстэн ястантай бөгөөд түүнийгээ дагасан олон хэл, шашин, улс төрийн намуудтай байдгаараа онцлогтой байж түүнийгээ өөрийн сургалтын системд шингээсэн байдаг. Энэтхэгчүүд өөрсдийгөө бүхэл бүтэн нэгэн тив гэж үзэж үндэсний онцлог, түүх соёлоо, зан заншлаа эрхэмлэн дээдэлж, өөрийн орны үндэсний эрх ашгаа бүхний дээгүүр тавьдаг.

Сүүлийн үед оюунлиг мэдлэгт тулгуурласан боловсрол, үйлдвэрлэл Энэтхэгт их газар авч хөгжиж байна. Энд юу хэлэх гээд байна вэ гэвэл Мэдээллийн технологи программын сургалт гол суурь эзэлж байна. Энэтхэгт энэ чиглэлээр сургууль төгссөн оюутныг Европын холбооны гишүүд болон АНУ -ын компаниуд уралдан авч, өндөр цалин олгож байна.

Мэдээллийн технологи программ хангамж, коол centruудийг түлхүү хөгжүүлж, далайд гарцгүй монголчууд бид өөрсдийн зохиосон программ хангамжаа сүүлийн үеийн харилцаа холбоогоор явуулаад суух сайхан боломж бий болж байна. Өөрөөр хэлбэл гадаадад өнөөгийнх шиг хараар биш цагаанаар ажиллах цаг ирэх юм. Түүнд энэтхэг нөхдийн бүх талын тусламж дэмжлэг туйлын чухал байж, энэтхэгчүүдийн энэ салбарт сунгаж байгаа тусламж дэмжлэгийг зөв зүйтэй ашиглах хэрэгтэй байна.

Ийм чиглэлийн үйлдвэрийн гол төвүүд нь Банглор, Мумбай, Хайдерабад, Ченнай, Дели хотод төвлөрч байна.

Дараагийн нэгэн гол эрч хүчээ аван хөгжиж байгаа салбар бол Биотехнологи юм. Энэ салбарт Энэтхэг хөгжилтэй европ, америкийн орнуудтай эрчимтэй хамтран ажиллаж байна. Энэ салбарын Энэтхэгийн суурь судалгаа ч олон улсын хэмжээнд үнэлэгдэж байна.

Өнөөдөр өрнөдөд ямар онол, шинэ санаа гарч байна, тэдний дунд олон энэтхэг гаралтай хүмүүс ажиллаж байдаг. Энэ нь өрнөдөд гарсан шинэ онол, санаа, судалгаа Энэтхэгт мөн өдрөө хүрэлцэн ирэх боломжийг олгож, Энэтхэгийн эрдэмтэд өөрсдийн хувь нэмрээ дэлхий дахинд оруулж байна.

Энэтхэгийн эрдэмтэн багш нар Дэлхийн шинжлэх ухаан, Мэдээллийн технологи, биотехнологи, сансар судлал, анагаах ухаан, эм үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт дэлхийн том гүрнүүдтэй өрсөлдөн, тэр хэмжээнд ажиллаж, зарим хэсэгтээ тэргүүлэх чиглэлдээ ороод байна. Ийм л хэмжээнд хүрсэн орны туршлагатай хүмүүсээр манай оюутнууд бусдын нэгэн адил хичээл заалгах юм. Ялангуяа мэдээллийн технологийн салбарт Энэтхэгтээ хамгийн нэртэй 5 их сургууль бий. Тэд дэлхийн хэмжээний болон Азийн тэргүүн сургуулиудад хамаарагддаг. Тэнд суралцахын тулд маш өндөр оноо авч олон мянган хүмүүстэй өрсөлдөх шаардлага гарна. Тэнд 99.99 балл авсан хүмүүсээс шалгаруулан авдаг. Түүний зэрэгцээ мэдээллийн технологийн олон коллежүүд бас бий. Түүнчлэн зөвхөн мэдээллийн технологийг дагнан зааж диплом олгодог хэд хэдэн том компаниуд байж тэд өөрийн салбараа дэлхийн олон оронд тухайлбал манай хоёр хөрш Орос, Хятадад байгуулаад байна. Тэднийг NIIT, APTECH гэнэ. Тэнд суралцах хугацаа янз бүр байдаг. Энэ хоёр компанийн салбарыг Монголд байгуулахад зохимжтой.

Багш нар хичээлээ заахын зэрэгцээ унших номын жагсаалт, ямар сургуулийн хэний бичсэн ном унших шаардлагатай, хэний ямар лекц, ярианд заавал сууж сонирхох талаар чиглэл өгдөг

Сургууль бүрийн номын сан үнэхээр баялаг сайхан. Тэндээс оюутнууд холдож чаддаггүй гэж хэлж болно. Түүний зэрэгцээ мэргэжлийн сэтгүүл, сонинг оюутнуудад зориулан номын санд олноор тавьсан байдаг.

Хичээл англи хэлээр явагдана. Иймд оюутан өөрийгөө шууд лекц ойлгох хэмжээнд бэлдсэн байх шаардлагатай. Та 12 жил англи хэл үзчихсэн гэр орондоо англиар ярьдаг оюутнуудтай хамт суралцах тул эхний үед бэрхшээл гарч болзошгүй.

Гадаад хэл заах онцлог

Гадаад хэлийг заахдаа нялх хүүхдийн өсөлт бойжилт дээр тулгуурлан заах онолыг баримталдаг. Жишээ нь гадаад хэл заахдаа эхлээд уг хэлний үг, өгүүлбэрийг зөв сонсч сурах, дараа нь түүнд хариу өгөх хэмжээнд хүрэх шаардлагатай гэж үзэж хинди хэлээ шинээр суралцагчдад заадаг. Энэ онолоор хэл үзсэн хүн хэдэн долоон хоногийн дараа уг хэлээр бага зэрэг ярих, хариу хэлэх хэмжээнд хүрдэг. Тэр үед нь уг хэлний үсэг зааж эхэлдэг. Өөрөөр хэлбэл үг үсгээ шууд бичихээс өмнө сонсч, ярьдаг

болгох оролдлого хийдэг. ХҮҮХЭД ХЭЛД ОРООД СУРГУУЛЬД ОРДОГ гэсэн дарааллыг гадаад хэл заахдаа баримталдаг онцлогтой.

Англи хэлний давуу тал

Англи хэл гадаад хэл боловч Энэтхэгт гадаад хэлд тооцогддоггүй. Англи албан ёсны хэлний нэг. Ийм учраас Дорно дахины сайхан сургааль онол, хэллэгийг Энэтхэгчүүд чадварлагаар орчуулан англи хувилбараа олчихсон бэлэн хэллэгүүд байгаагаас манай хэвлэлийнхэн англиар гардаг сонин сэтгүүлийнхэн сурах хэрэгтэй байж болох юм.

Дэлхий дахины холбоо хэл болох англи хэлээр хичээл заах, энэ хэлээр сэтгэх, бичиг баримт боловсруулахыг Энэтхэг сэхээтэн хүн үүргээ гэж үздэг. Энэтхэгчүүд дэлхийн соёл, хөгжил, шинжлэх ухааны ололт амжилттай мөр зэрэгцэн оршиход АНГЛИ хэл их үүрэг гүйцэтгэсэн. Тэрчлэн энэтхэгчүүд англи хэлийг баяжуулан 900 гаруй үг тэнд оруулсан гэж ярьдаг.

Манай оюутны хувьд англи хэлтэй түүний хажуугаар мэргэжилтэй болоод ирэх бүрэн боломжоор хангагдаж байна гэсэн үг юм. Зарим авьяастай оюутан хинди хэл давхар сурсан байдаг. Монгол хүнд Англи, Орос, Хятад зэрэг гадаад хэл зайлшгүй шаардлагатайн адил энэтхэг хүнд хинди, англи болон өөрийн төрөлх хэл зайлшгүй шаардлагатай байдаг. Сургуулийн болон дотуур байрны дотоод дэг журам маш хатуу. Оюутнууд багш нар архи хэрэглэдэггүй. Тийм соёл, уламжлал байхгүй. Энэтхэгийн нийгэм архи хэрэглэсэн хүнийг хүлээж авдаггүй. Архи уугаад гуйваад явж байгаа нэг ч хүнийг Делийн гудамжинд 20-д жил байхдаа хараагүй.

Сүүлийн үед манай эцэг эхчүүд Энэтхэгийн дунд сургуульд хүүхдээ явуулж байгаа. Хамгийн сайн чанартай, үнэтэй дунд сургуулиуд сэрүүн уулархаг нутгаар байдаг. Дунд сургуулийн зарчим бол хүүхдүүд сурагчийн ижил дүрэмт хувцастай байж, ээмэг бөгж, алт мөнгө зэрэг үнэтэй эд зүйл хэрэглэхийг хориглосон байдаг. Зарим дунд сургуулийн хүүхдэд зориулсан сургуулийн автобус байдаг. Хувийн машинаар ирэхийг хориглодог. Энэ нь хүүхдийг ижил түвшинд суралцах боломж олгодог. Та гэртээ 10 машинтай байсан ч сургуулийн унаагаар л ирэх ёстой. Гар утас хэрэглэхийг нэгэн адил хориглоно. Энэ нь хүүхэд бүрт ижил боломж байдаггүйтэй холбоотой, нөгөөтэйгүүр хүүхдийн гол зорилго бол зөвхөн сурах гэсэн ОНОЛТОЙ.

Багш нар болон оюутан сурагчид гадаадын оюутантай их нөхөрсөг сайн харилцдаг. Тэдний соёл, түүхийг сонирхдог. Их зочломтгой ард түмэн.

Гэхдээ Энэтхэгийн хүн амын 30-40 хувь мах иддэггүй. Тэр тусмаа үхрийн мах, гахайн махыг хинду, лалын шашинтан иддэггүйг үргэлж санаж ойлгон, суралцах ёстой. Энэтхэг хүмүүс маш цэвэрч, өдөрт хүмүүс голдуу 3 удаа усанд ордог.

Энэтхэг хүмүүсийн иддэг хоол маш өвөрмөц онцлогтой. Голдуу халуун ногоотой хоол иддэг.

Энэтхэгт суралцах оюутнаас их хүч, хөдөлмөр, мэрийлт шаардагдана. Түүний зэрэгцээ хөнгөн амьдралыг нийгэм нь хүлээн авдаггүй. Хөнгөн амьдралаар амьдрах дуртай хүмүүст үүд хаалга нь хаалттай. Эрдэм ном сурахын төлөө хүмүүсийн өлгий нутаг гэж ойлгож болно.

Шалгалт хэрхэн авдаг тухай

Манай зарим монгол оюутан шиг багшид хэлүүлж дүн авах, юм хуулж дүн авах зэрэг арга тэнд байхгүй, үйлчилдэггүй. Сургуулийн бүх шалгалтыг бичгээр авдаг. /Гадаад хэлний аман ярианаас бусад/. Иймд гадны нөлөө хүчин гэж гардаггүй.

Нийт асуултын 30 аад хувь нь заагаагүй зүйл байж болдог. Оюутан уг мэргэжлийн дагуу бие даан суралцаж, юм сонирхон уншсан байх ёстой гэж үзэн бие даасан, бүтээлч хандлагад гол анхаарлаа хандуулдаг. Шалгалтын хуудсыг өөр хотын ижил төсөөтэй сургуулиудын аль нэгэнд хүргүүлж, тэндхийн багшаар шалгуулаад буцаан авдаг. Тэр хуудас нь кодтой тул хэний ажлыг шалгав гэдгээ тэр багш мэддэггүй. Тэр сургууль нь жил бүр солигдож байдаг тул шалгалтанд ямар ч арын хаалга байдаггүй. Хичээл заасан хэлний багшийг оюутнуудын нь аман шалгалтанд оруулдаггүй.

Техникийн их сургуулиудын номын сангийн хүмүүс нь шөнийн 12 цагт хаалгаа барихад оюутнууд сунгаж өгөхийг гуйж, хүсэлт тавьж зовоодог талаар номын санч ярьж байсан юм байна.

Том том сургуулиуд өөр өөрийн оюутны хотхонтой байж хотын их хөдөлгөөнөөс алслагдсан газар сурах боломжоор бүрэн хангагдсан байдаг. Өөрөөр хэлбэл тэнд зөвхөн оюутны хэрэглээний шаардлагатай зүйл байна уу гэхээс оюутныг уруу татсан архи, бар, зугаа цэнгээний газар байдаггүй. Оюутнууд ч тийшээ явдаггүй. Шалгалтын хариултыг ном уншаад хариулаад биччих аваас багш нар өндөр оноо тавьдаггүй. Гэхдээ та шалгалтанд унахгүй. Харин өндөр оноог хэзээ тавих вэ гэвэл уг асуудлаарх өөрийн бодол санаа, шүүмж, Энэтхэгийн хөрсөнд юу нь таарах, юу таарахгүй, юу хэрэгтэй, хэрэггүй талаар үнэлэлт дүгнэлтээ оюутан өөрөө гаргавал өндөр оноо авдаг онцлогтой.

Монгол оюутан Энэтхэгт

Манай оюутнуудын хувьд англи хэлээр хичээлээ үзээд, нарийн мэргэжилтэй болоод төгсөнө гэдэг бол ховорхон боломж гэж хэлмээр байна.

Энэтхэгийн багш нар олон жил хичээл заасан туршлагатайн зэрэгцээ өнөө ирээдүйн өөрчлөлт төлөв байдлыг маш нарийн тусгаж хичээлээ явуулдаг. Номын санд таны мэргэжлийн бүх ном сурах бичгээр болон өдөр дутмын гадаад дотоод хэвлэлээр хангагдсан байдаг. Шалгалт авах ёс дүрэм маш нарийн, бүх шалгалт бичгээр өгдөг талаар дээр тэмдэглэсэн. Иймд бэлтгэл, хичээлээ цаг тухайд нь давтан, өөрийн мэргэжлийн чиглэлийн ном, зохиол бие даан унших шаардлагатай. Тэгэхдээ уншиж байгаа зүйлдээ бүтээлчээр хандахыг шаардана. Амьдралын өөрийн өртөг хямд, засгийн газраас олгодог мөнгөөр амьдраад байх бүрэн боломжтой.

Цаг агаарын хувьд Энэтхэг өөрийгөө бүхэл бүтэн тив гэж үздэг тул янз бүрийн уур амьсгалтай. Халууны улиралд амьдрах чадвартай хүн явах хэрэгтэй. Нутгийн төв хойт хэсэг хуурай халуун уур амьсгалтай, өмнөд хэсгээр чийглэг, зүүн хойт хэсэг Гималайн нурууны сав газар сэрүүн уур амьсгалтай. Англиас гадна хинди болон орон

нутгийн олон хэлээр ярьдаг. Олон шашинтай, олон намын системтэй. Ардчилал дээд зэргээр хөгжсөн орон.

Энэтхэг эртний түүх, соёл, иргэншил, өнөөгийн ШУ-ны орон. Энэтхэгт үзэх танилцах түүх дурсгалын маш олон зүйл бий. ЮНЕСКО гийн бүртгэлд орсон 30-аад түүх дурсгалын зүйлстэй. Түүний зарим нь дэлхийн гайхамшигт ордог.

Бурхан багшийн амьдрал ахуйтай холбоотой түүхэн дурсгалын газрууд 8-9 байдаг. Монголчууд тэнд очиж мөргөдөг. Бурхан багшийн гэгээрсэн газар Бодгаяад Монгол сүм байгуулах газар авах асуудлыг би элчин сайд байх үеэсээ хөөцөлдөж хэрэгжүүлдсэндээ баяртай байдаг. Одоо тэнд 4 давхар сайхан сүм сүндэрлэн босч байна.

Зуны амралтаар Энэтхэгийн ГХЯ-ны харьяанд байдаг Гадаадтай соёлоор харилцах зөвлөл буюу ICCR-аас тусгай хөтөлбөр гаргаж Энэтхэгийн нутгаар аялах боломж олгодог. Заримд нь цастай Гималайд, нөгөө хэсэгт нь далай руу явах боломж олгодог. Эсвэл нутагтаа амралтаараа ирж болно. Одоо Бээжин Делийн хооронд шууд нислэгтэй болсон.

Энэтхэгт сургууль төгсөгчид

1990-д оноос Энэтхэгийн их дээд сургуульд манайхан өргөнөөр суралцах болж Энэтхэгийн Засгийн газар цалин олгож эхэлсэн. Энэ хугацаанд Энэтхэгт их дээд сургууль төгсөгчдийн тоо жил бүр дунджаар 20-30 гэж үзвэл 300-500-д хүрч байгаа. Түүн дээр мэргэжил дээшлүүлэгчдийн тоо жил бүр 40-50 хүн гэж бодвол, энэ тоо 700-800-д хүрч байна. Энэтхэгт сургууль төгссөн хүн бүр ажилтай байгаа. Тэд англи хэлтэй, мэргэжилтэй тул Төр, засгийн байгууллага, ОУБ, УБ дахь ЭСЯ, гадаадын олон төсөл дээр ажиллаж байна. Тэдний дотор төрийн сайд, УИХ гишүүн, Яамны төрийн нарийн бичгийн дарга болон Монгол Улсад хэрэгжиж байгаа олон төсөл дээр ажиллаж Монгол улсынхаа төлөө зүтгэж байгаа хүмүүс олон байна.